

ГАДААДАД СУУГАА МОНГОЛЧУУДААС ТӨР ЗАСАГТАА ТАВИХ ШААРДЛАГА

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц. Элбэгдорж, Ерөнхий Сайд Н. Алтанхуяг,
УИХ-ын дарга З. Энхболд болон УИХ-ын нийт гишүүдэд хандах нь:

Гадаадад сурч, ажиллаж буй эх орноо гэсэн халуун сэтгэлтэй олон мянган монголчуудын төлөөлөл болсон бидний хэсэг иргэд Монгол Улсын Үндсэн хуулийн 3.1-р заалтаар баталгаажсан “төрийн үйл хэрэгт шууд оролцох”, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 14.2-р заалтаар олгогдсон “үндэсний аюулгүй байдалд хохирол учруулж болзошгүй асуудлаар төрийн зохих байгууллага, албан тушаалтанд санал гомдлоо тавьж шийдвэрлүүлэх” эрхээ эдэлж дараахь шаардлагыг та бүхэнд хүргүүлж байна.

Сүүлийн үед Монголын эдийн засаг, нийгэм улс төрд гадныхны ноёрхлыг тогтоохын төлөө хэт улайрсан үйлдлүүд хэрээс хэтэрч буйд Монгол улсын жинхэнэ эзэд, иргэд бид нэн түгших боллоо. Тухайлбал, Монгол улсын газар нутаг, эрдэс баялгийг харийнханд найр тавин олгох зорилготой хэсэг бүлэг хүмүүс холбогдох хуулиудыг яаравчлан шинэчилж, нэмэлт өөрчлөлт оруулахаар санаархаж буй нь Монгол улсын тусгаар тогтнол, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, Монгол ард түмний удмын сангийн аюулгүй байдал, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, хөрөнгө өмчлөх, эзэмших эрх, газар нутаг ард түмний мэдэлд байх, бэлчээр өмчлүүлэхийг хориглох тухай Үндэсний аюулгүй байдлын тухай болон Үндсэн хуулийн заалтуудыг ноцтой зөрчин, үндэсний язгуур эрх ашигт тэрсэлж байгаа тул нэр бүхий хуулиудыг эргүүлэн татаж, одоо хэлэлцэгдэж буй хуулийн төслүүд болон хэрэгжиж эхэлсэн төсөл санаачлагуудыг нэн даруй таслан зогсоохыг бид хатуу шаардаж байна. Үүнд:

- 1. Газрын тухай, Ашигт малтмалын тухай, Газрын тосны тухай зэрэг онц чухал хуулиудыг шинэчлэх төслүүдийг зогсоох.** Цаашид эдгээр хуулиудыг шинэчлэн засварлах төслүүдийг иргэний нийгэм, ард иргэдийн хяналтан дор олон нийтийн нээлттэй санал асуулга явуулж батлуулж байх. *(Дэлгэрэнгүй тайлбарыг Хавсралт Нэгээс үзнэ үү).*
- 2. Асар их хор хөнөөлтэй цацраг идэвхит ашигт малтмал, үүнд уран болон газрын үнэт металл олборлох, атомын цахилгаан станц барих, гадныхны ашигласан цөмийн түлшийг эргүүлж авах, Монголд цөмийн хаягдал булшлах далд зорилготой Цөмийн энергийн хуулийг хүчингүй болгож,** ард иргэд, иргэний нийгмийн тэгш оролцоотойгоор шинэчлэх. *(Дэлгэрэнгүйг Хавсралт Хоёроос үзнэ үү).*

3. Монгол улсын тусгаар тогтнол, үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн **нарийн царигтай төмөр зам барих, Хятадын төрийн өмчийн Банк**ийг (Bank of China) Монголд оруулах санаачлагуудыг таслан зогсоох. 2010 онд батлагдсан “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогыг” баримталж ажиллах.

4. Дээр дурьдсан хуулиуд болон хуулийн төслүүдийг **санаачлагч байгууллага, эрх мэдэлтнүүдийг нийтэд ил тод зарлаж, тэдэнд хариуцлага тооцох**. Тухайлбал, Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулиудыг зөрчин Монголын газар нутгийг гадаадын аж ахуйн нэгжид эзэмшүүлэх, өмчлүүлэх зорилготой Газрын тухай хуулийн төслийг боловсруулж, ард иргэдэд буруу ташаа мэдээлэл өгч төөрөгдүүлсэн ажлын хэсгийн ахлагч **Ц.Баярсайхан, Г.Баярсайхан, Б.Гарамгайбаатар** нарыг Монгол улсын эрх ашгаас урваж, үндэсний аюулгүй байдалд заналхийлсэн гэмт хэрэг үйлдэхээр завдсанд тооцож, хатуу шийтгэхийг тус тус шаардаж байна.

Энэхүү бичгийг хүлээн авснаас хойш долоо хоногт багтааж буюу 2014 оны 10 сарын 13-ны дотор олон нийтийн мэдээллийн хэрэгслээр хариу өгөхийг шаардаж байна. Шаардлагын дагуу хариу арга хэмжээ аваагүй тохиолдолд бид Монголд болоод олон улсад эсэргүүцлийн арга хэмжээ зохион байгуулж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий Сайд болон УИХ-ын гишүүд нь хуурамч ардчилал, хүний эрхийн халхавчин дор эх орон, ард иргэдийнхээ эрх ашгийг уландаа гишгэж, эх орноосоо урван тэрсэлснийг олон улсад зарлаж, эрх ашгаа хамгаалан олон улсын шүүхэд хандана гэдгээ мэдэгдэж байна.

Гадаадад суугаа Монголчуудыг төлөөлж:

Америкаас 1194 иргэн

Англиас 355 иргэн

Даниас 5 иргэн

Ирландаас 156 иргэн

Францаас 40 иргэн

Швейцараас 219 иргэн

Японоос 161 иргэн

Өмнөд Солонгосоос 270 иргэн

Нийт 2400 иргэн энэхүү шаардлагыг дэмжиж гарын үсэг зурсаныг

Хавсралт Гурав-аар хүргүүлэв.

2014 оны 9 сарын 19

ХАВСРАЛТ НЭГ

Газрын тухай, Газрын тосны тухай, Ашигт малтмалын тухай хуулиуд болон шинэчлэн найруулсан төслүүд нь Үндсэн хуулийн дараахь заалтуудыг ноцтой зөрчиж байна.

Тухайлбал:

- 1) 2002 оны 6-р сарын 7-нд УИХ-р батлагдсан Газрын тухай хуулийн тусгай хэрэгцээний газрын ангилалын 16.1.10-д “цөмийн төхөөрөмж барих, ашиглах зориулалтаар олгосон газар” гэж тусгасан нь Үндсэн хуулийн 16.2-д заасан эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг;
- 2) 2013 оны 1 сард боловсруулан Газрын тухай хуулийн төслийн 2.3-р заалт нь Үндсэн хуулийн 1.1, 6.1-н “Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн”, “Монгол Улсад газар [...] гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна” гэсэн заалтыг;
- 3) Газрын тухай хуулийн төслийн 15.5, 17.1.5-д гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид 15-60 жилийн хугацаатайгаар газар эзэмших, 40 хүртэл жилээр сунгах эрх олгохоор заасан төдийгүй 27.1.7-р заалтаар газар өмчлөх эрхийг хамтад нь нээж өгч байгаа нь Үндсэн хуулийн 6, 11.1, Газрын тухай хуулийн төслийн 15.2-д тусгасан заалтуудыг;
- 4) Газрын тухай хуулийн төслийн 12, 17, 23, 24, 42 дугаар зүйлд гадаад, дотоодын иргэншлээс үл хамааран авсан эрхийн дагуу газар эзэмших хүсэлтээ гаргаж, урт хугацаагаар эзэмших боломжтойгоор тусгасан нь Үндсэн хуулийн 6.1, 6.3 заалтуудыг;
- 5) Газрын тухай хуулийн төслийн 22 дугаар зүйлд бэлчээрийг эзэмшүүлэхээр тусгасан нь Үндсэн хуулийн 6.3-р заалтыг тус тус зөрчиж байна.

Түүнчлэн Газрын тухай хуулийн төслийн 15.6, 30.1-д иргэд газраа барьцаалах, дуудлага худалдаагаар худалдах эрхтэй гэж заасан нь газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах зорилготой мэт харагдавч эдийн засгийн хүндрэл бэрхшээлийг даван туулахын тулд ард иргэд газраа бусдад худалдаж, улмаар санхүүгийн боломжтой хэсэг бүлэг хүмүүсийн гарт газар өмчлөх эрх төвлөрөх эрсдлийг агуулж байна. Ингэвэл 1990-д оны эхээр өмч хувьчлал нэр дор цэнхэр, ягаан тасалбар тарааж, цөөн гэр бүл хөрөнгөжсөн түүх давтагдаж, нийгмийн тэгш бус байдал улам гаарч, газрын үнийг хөөрөгдөх аюултай төдийгүй улс орны тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, үндэсний аюулгүй байдалд аюул заналхийлэл учруулах эрсдэл тодорхой харагдаж байна.

Газрын тухай хуулийн төслийн 22 дугаар зүйлд малын бэлчээрийг хувьчлах тухай тусгасан нь Монгол улсын түүхэн уламжлалт нүүдлийн мал аж ахуйг устган мөхөөж, нийгэм, эдийн засаг, экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулах ноцтой аюул агуулсан тул бид эрс эсэргүүцэж байна. Манай улс 1926 оны Засгийн Газрын 227 дугаар тогтоолоос хойш бэлчээр, өвөлжөө бууцаар нэгнээ гачигдуулан хохироож, илүү нутаг эзэрхэх явдлыг зогсоох, хүн мал идээшсэн, хөрөнгө малын олон цөөний байдалд тохируулан бууц бэлчээрийг зүй зохистойгоор ямар ч үнэ төлбөргүй, хугацаагүйгээр ашиглуулдаг зарчмыг баримталж ирсэн. Цаашид ч энэ зарчмыг Монгол Улсын Үндсэн хуулинд тусгасан байдлаар нь чандлан мөрдөхийг шаардаж байна.

ХАВСРАЛТ ХОЁР

2009 оны 7 сард батлагдсан Цөмийн энергийн хууль нь гадны улс орнуудын ашигласан цөмийн түлшийг Монголд булшлах гарцыг нээж, улмаар Монгол улсын үндэсний аюулгүй байдал, хүн ам, удмын сан, байгаль экологид заналхийлж, Монгол иргэдийн амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг ноцтой зөрчиж байна. Тухайлбал:

- 1) Тус хуулийн 3.1.6-д “цөмийн төхөөрөмж” гэдгийг “цөмийн түлш бэлтгэх үйлдвэр, цөмийн болон судалгааны реактор, цөмийн эрчим хүчний эх үүсвэр, цөмийн түлш болон ашигласан түлш хадгалах байгууламж, баяжуулах үйлдвэр, ашигласан түлшийг дахин боловсруулах үйлдвэр” гэж тодорхойлсон нь утгыг бүрхэгдүүлсэн, нэн аюултай нэр томъёо болжээ.

Тайлбар: Дээрх нэр томъёонд орсон олон зүйлийг **АЦС** (цөмийн эрчим хүч үйлдвэрлэх цөмийн реактор) ба **Цөмийн хаягдал** (цөмийн түлш үйлдвэрлэх, цөмийн ашигласан түлш хадгалах, дахин боловсруулах) гэж 2 ангилж болно. Ийнхүү ялгаатай олон ойлголтыг ганц нэр томъёон дор хуульчилсан нь Цөмийн энергийн хуулийг будлиантуулж, зориудаар хуулийн “цоорхой” үүсгэх гэсэн оролдлого гэж үзэх үндэслэл байна. Учир нь өнөөдөр манай гариг дээр хуримтлагдсан цөмийн хаягдал, тэр тусмаа ашигласан цөмийн түлшний асуудал нэн хурцаар тавигдаж байна. Дэлхий даяар ашигласан цөмийн түлш дахин боловсруулах 20 гаруй байгууламж баригдсан ч ажиллаж буй нь ердөө гарын таван хуруунд багтах юм. Цөмийн хаягдлыг дахин боловсруулах нь 1-рт, эдийн засгийн хувьд шинээр уран олборлосноос хавьгүй алдагдалтай; 2-рт, технологи нь дэндүү болхи, осол гарах эрсдэл өндөртэй, үйлдвэрлэх хүчин чадал багатай; 3-рт, засвар нь удаан, өртөг зардал өндөртэй; 4-рт, дахин боловсруулалтын явцад дахин ашиглах боломжгүй, булшлах шаардлагатай цөмийн хог хаягдал асар ихээр гардаг, 5-т, дахин боловсруулнаар цөмийн хаягдлын эзлэхүүн хэмжээ нь төдийлэн их буурдаггүй байна. Нарийн тооцоотой Германчууд цөмийн хаягдал дахин боловсруулах 2 ч байгууламж барьсанаа ажиллуулж үзэлгүй хаасан. Ихэнх улс орнуудын хувьд эдийн засгийн үр өгөөж болон аюул эрсдэл, хор хөнөөлийг харгалзаж үзээд АЦС-д ашигласан цөмийн түлшний хаягдлаа тэр чигээр нь хадгалж эсвэл буурай хөгжилтэй улс орнууд руу сэмхэн зөөж, зарим улсын улс төрчидтэй нь хуйвалдан “дахин боловсруулах” нэрээр гаргаж ирсэн түүхтэй.

Монгол улсад ч бас “дахин боловсруулах” нэрээр гадны цөмийн хаягдал орж ирэх боломж бүрдсэн талаар Ерөнхийлөгч Ц. Элбэгдоржийг 2011 оны 6 сард АНУ-д айлчлахын өмнөхөн АНУ-ын Конгрессын дэргэдэх судалгааны төвөөс гаргасан “*Mongolia: Issues for Congress*” тайланд (х.14) дурьдсан билээ. Иймээс Цөмийн энергийн хуулинд "ашигласан түлшийг дахин боловсруулах үйлдвэр" хэмээн дурьдсан нь ирээдүйд гадны ашигласан түлшийг цөмийн хаягдал биш "дахин боловсруулах түүхий эд" хэмээн нэрийдэж Монгол Улсын хилээр нэвтрүүлэх зорилготой тусгагдсан байна.

- 2) Тус хуулийн 3.1.16-д “цацраг идэвхт хаягдал гэж цацраг идэвхийн хэмжээ нь хаягдлын стандартад заасан зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн, ямар ч төлөв байдалд байж болох, цаашид дахин хэрэглэгдэхгүй зүйлсийг хэлнэ” гэж тодорхойлжээ.

Тайлбар: Орчин үеийн технологийн дэвшил ямар ч хог хаягдлыг дахин боловсруулах түвшинд хүрсэн тул дахин боловсруулах боломжтой гэдэг нь эдийн засгийн үр өгөөжтэй, осол аюулгүй, практик ач холбогдолтой гэсэн баталгаа биш. Энэ тодорхойлолт нь хамгийн өндөр түвшний цацраг ялгаруулдаг цөмийн хаягдал буюу ашиглагдсан цөмийн түлшийг “дахин боловсруулах” нэрээр Монгол руу зөөх гарцыг нээж байна.

- 3) Цөмийн энергийн хуулийн 3.1.22-т “цацраг идэвхт хаягдал булшлах гэж зөвхөн өөрийн орны цацраг идэвхт хаягдлыг булшлахыг хэлнэ” гэжээ.

Тайлбар: Энэ нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Монголчууд өөрсдийн зорилгоор ашигласан цацраг идэвхит тоног төхөөрөмж, цацрагт материалын хаягдлыг хэлж байна уу (жишээлбэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, түүний хаягдал) эсвэл Монгол улсад олборлосон буюу Монголоос гаралтай ураныг гадны улс орнууд цөмийн түлш болгож ашиглаад буцааж Монголд булшлахыг хэлж байгаа эсэх нь тодорхойгүй, хуулийн “цоорхой” бий болгосон туйлын бүрхэг заалт юм.

- 4) Түүнчлэн, Цөмийн энергийн хуулийн 8.1.1, 8.1.2 гэх мэт заалтуудад тус хуулийн нэр томъёоны тайлбар хэсэгт тодорхойлж тайлбарлаагүй цоо шинэ үг болох "цөмийн технологи" гэдэг нэр томъёо ашигласнаар хуулийн утга санааг зориудаар бүрхэгдүүлжээ. Тухайлбал, цөмийн циклийг Монголд хэрэгжүүлж, гадны ашигласан түлшийг булшлах нь цөмийн технологийн нэг хэсэг гэж тайлбарлах боломж бүрдэж байна.

- 5) Хуулийн 9.1.3-т “цацраг идэвхт ашигт малтмал болон цөмийн энерги ашиглах, цөмийн технологи нэвтрүүлэх, цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан Олон улсын атомын энергийн агентлагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах” гэжээ.

Тайлбар: Цөмийн хаягдал олон улсын хурцадмал асуудал болсон өнөө үед Олон улсын атомын энергийн агентлагийн баримталж буй нэг чиглэл нь уран олборлогч улс нь олон улсын эсвэл бүс нутгийн хэмжээнд хангагч улс болж, бусад улс орнуудад уран болон цөмийн түлш нийлүүлж, хариуд нь цөмийн хаягдлыг нь авч нутагтаа булшлахыг дэмжин нэвтрүүлэх явдал юм. Энэ нь Үндсэн хуулийн 10.4 буюу “Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй” гэсэн заалт, 16.1, 16.2 буюу Монгол Улсын иргэн амьд явах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхтэй гэдэг заалтуудыг зөрчиж, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 19.1 буюу Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутгийн нүрэн бүтэн байдал, үндэсний язгуур эрх ашиг сонирхолд харш олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулахыг хориглосон заалттай харш юм.

- 6) Тус хуулийн хэд хэдэн заалтанд гадны ашиглагдсан цөмийн түлшийг Монголд булшлах хуулийн “цоорхойг” бий болгож, ард иргэдийн амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчиж байна. Тухайлбал, 9.1.8, 11.6.13-р заалтуудад цөмийн хаягдал, ашиглагдсан цөмийн түлшийг хадгалах болон цөмийн материалыг улсын хилээр нэвтрүүлэх тухай заажээ. Тус хуулийн 3.1.12-т “цөмийн материал” гэж цөмийн реактор болон цөмийн зэвсэгт ашиглагддаг материал гэж тайлбарласан бөгөөд 33-р зүйлд Монгол улсын нутаг дэвсгэрт зэвсгийн зориулалттай цөмийн материалыг боловсруулах, үйлдвэрлэх, бусад аргаар олж авах, эзэмших, хадгалахыг хориглосон тул 11.6.13-т заасан цөмийн материал нь ашигласан цөмийн түлш байх боломжтой юм.

- 7) Цөмийн энергийн хуулинд ашиглагдсан цөмийн түлшийг Монголд булшлахдаа аюулгүй аргаар хэрэгжүүлнэ хэмээн ард түмнийг хууран мэхэлж, улмаар ард иргэдийн амьд явах, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхэнд халдаж байна. Тухайлбал, 9.1.8-д “цөмийн хаягдал, ашиглагдсан цөмийн түлшийг хүн ам, нийгэм, байгаль орчинд аюулгүй хадгалах урт хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх” гэж заажээ.

Тайлбар: Өнөөг хүртэл дэлхийн хамгийн хөгжингүй улс орнууд хүртэл асар хортой хаягдал ашигласан цөмийн түлшийг урт хугацаагаар аюулгүй хадгалах арга технологи

бүтээж чадаагүй төдийгүй ашигласан түлшийг урт хугацаагаар хадгалах аргыг туршиж үзсэн ганц ч улс орон ганц ч байхгүй. Ийм үед цөмийн салбарт дөнгөж хөл тавьж буй Монгол улс “ашиглагдсан цөмийн түлшийг хүн ам, нийгэм, байгаль орчинд аюулгүй хадгалах урт хугацааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ” (9.1.8) гэдэг заалт нь хуулиар сүр далайлган ард иргэдийг мэхэлж, Монгол улсыг цөмийн хаягдлын булш, туршилтын агуулах болгох санаархлыг илэрхийлж байна.

- 8) Түүнчлэн, төрийн захиргааны байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөлтэй этгээд 15.1.3-т зааснаар цөмийн бодис эзэмших, ашиглах, худалдах; 15.1.4-т зааснаар цөмийн бодис импортлох, экспортлох, тээвэрлэх, хаягдлыг булшлах эрхтэй ажээ. Цөмийн бодис гэдэгт ашигласан түлш багтдаг тул тусгай зөвшөөрөлтэй хэн нэгэн этгээд цөмийн ашиглагдсан түлш экспортлох импортлох эрхтэй болж байна.
- 9) Мөн саяхан Хятадын ерөнхий сайдын айлчлалаар хийсэн гэрээнд олон улсын транзит тээврийн талаар чухал алхмууд хийгдсэн нь Цөмийн энергийн хуулийн 39.2 буюу “Цөмийн материал болон цацрагийн үүсгүүр[...], тоног төхөөрөмжийн улс хоорондын тээврийг олон улсын холбогдох гэрээ, хэлэлцээр, дүрмийн шаардлагын дагуу гүйцэтгэнэ” гэсэн заалтыг хэрэгжүүлэх алхам болжээ гэж үзэж байна.